




SYSTEM KAN-therm



Олон системийн шугам хоолойн тоног төхөөрөмж

KAN Компани

KAN бол орчин үеийн, иж бүрэн суурилуулалтын систем-аараа алдартай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Польшийн үйлдвэрлэгч компани юм.

KAN компани нь 1990 онд байгуулагдсан цагаасаа хойш үйл ажиллагаагаа бат бөх суурь дээр мэргэжлийн ур чадвар, чанар, шинэлэг хөгжлийн стратеги дээр тулгуурлан босгодог билээ. Өнөөдрийн байдлаар энэхүү компанид 1200 гаруй хүн ажилладаг ба Польшид түүний сүлжээ салбарууд нь байдаг ба дэлхий даяар түүний худалдааны төлөөлөгчдийн газрууд байрладаг. KAN-therm гэсэн худалдааны тэмдэгтэй бүтээгдэхүүнүүд тив дэлхийн 68 улсад экспортлогддог юм. Албан ёсны дистрибьюторын сүлжээ нь Европ, Ази, Африк, Америкийн ихэнхи хэсгийг хамардаг.



> 30

Суурилуулалтын зах зээл дээр 30 гаруй жилийн туршлагатай

68

улсад KAN бүтээгдэхүүнээ экспортолдог

> 1200

Дэлхий даяар 1100 гаруй ажилтантай



SYSTEM KAN-therm

ultraLINE

Ø14-32 мм

Энэ нь стандарт дотоод халаалтын инженерчилсан систем болон тусгай шугам хоолойн сүлжээг суурилуулах, жишээлбэл шахсан агаарыг тээвэрлэх зориулалттай суурилуулалтын зах зээл дээрх шинэлэг, өвөрмөц давтагдашгүй техникийн шийдэл юм.

3 төрлийн хоолой
2 холбогч материал
1 цагираг хийц

Холбох хэрэгслийн өвөрмөц, цорын ганц гэж хэлж болох цагираггүй давтагдашгүй бүтэц, төгсгөлийн шийдлийн уян хатан тохиргоо нь суурилуулагч болон зураг төслийн ажлыг ихээхэн хялбаршуулж өгдөг. KAN-therm ultraLINE системийн уян хатан байдал нь нөгөө л гуулин эсвэл полимер холбох хэрэгсэл, түүнчлэн полимер цагираг ашиглан өөр өөр төрлийн хоолой ашиглах боломжийг өгдөгт оршино.

KAN-therm ultraLINE систем нь олон давхар орон сууцны барилгад халаалт, хөргөлтийн систем, усан хангамжийг орон сууцны айл тус бүрээр салаалуулан гүйцэтгэх маш сайн хувилбар юм. 32 мм хүртэл янз бүрийн диаметрын сонголт хувийн орон сууцны барилгад халаалт, хөргөлт, усан хангамжийн цогц системийг бий болгох боломжийг олгодог.



01

Материалын уян хатан сонголт

02

Тэгш хэмтэй суналтын цагираг

03

Гидравликийн оновчтой байдал

04

270° градусын цар хүрээнд суурилуулалт хийнэ

05

Цагираггүй холболт



SYSTEM KAN-therm

ultraPRESS

Ø16-63 мм

KAN-therm ultraPRESS – 16-63 миллиметрийн диаметрийн цар хүрээний PPSU полимераас эсвэл гуулин фитингуудаас, цаашлаад хөнгөн цагаан давхаргатай PERTAL полиэтилен хоолойнуудаас бүрдсэн орчин үеийн иж бүрэн инсталляц буюу суулгалтын систем юм.

16-32 миллиметрийн диаметрийн цар хүрээний ultraPRESS фитингууд нь "LBP" (Leak Before Press) давтагдашгүй функцтай бөгөөд холболтын явцад пресслагдаагүй хэсгийн илрүүлэлтийг хөнгөлнө. Тэдгээрийн тусгай бүтээц нь угсралтын тав тух болон аюулгүй байдлыг дээшлүүлэх нэмэлт олон шийдлийг хангаж системийн олон жилийн аваар осолгүй ашиглалтын баталгаа болно.

KAN-therm ultraPRESS нь дотоод халуун хүйтэн ус хангамжийн систем, төвийн дулааны болон хөргөлтийн систем, технологийн дулааны тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн суурилуулалтанд зориулагдсан юм (жишээ нь шахсан агаарын тээвэрлэлтэнд).



- | | | | | | |
|-----------|---|-----------|------------------------------|-----------|--|
| 01 | Пресслагдаагүй холболтуудын дохиоллын функц (LBP) | 02 | Хэрэглээний универсал салбар | 03 | Угсралт болон ашиглалтын аюулгүй байдал |
| 04 | Тав тухтай угсралт | 05 | Тохирох буюу нийцэх байдал | 06 | Фитинг дээрхи хуванцар цагирагны өнгөөр диаметрыг хөнгөн аргаар ангилан ялгах ба таних |



SYSTEM KAN-therm

PP

Ø16-110 мм

KAN-therm PP – энэ нь PP-R ба PP-RCT полипропиленээр хийсэн хоолой, холбогчуудын бүрдэл бүхий хамгийн бүрэн гүйцэд суурилуулалтын систем юм.



Системийг цахилгаан гагнуурын машин ашиглан ханцуйн (муфтовая сварка) гагнуурын аргаар (полифузын дулааны гагнуур) холбодог. Гагнуурын технологи нь холболтын нэгэн төрлийн байдлаас шалтгаалан системийн онцгой битүүмжлэл, механик бат бөх чанарын баталгаа болдог.

Өндөр механик эсэргүүцэл, ундны усны чанарыг үл харгалзсан байдал нь үүнийг ахуйн усан хангамжийн системд хамгийн тохиромжтойгоор тодорхойлж буй юм. Өргөн хүрээний диаметртай, зэврэлтэнд тэсвэртэй материал ашигласны ачаар KAN-therm PP нь хувийн болон олон давхар орон сууцны барилга, түүнчлэн нийтийн зориулалттай дотоод инженерийн халаалт, хөргөлтийн системийг суурилуулахад амжилттай ашиглагдаж болно.

01

Хэрэглээний универсал чанар

02

Хоолойны өргөн сонголт

03

Бат бэх холболтууд

04

Оновчтой гидравлик

05

Хамгийн сайн чанарын баталгаа



SYSTEM KAN-therm

Steel

Ø12-108 мм

KAN-therm Steel – энэ нь гадна талдаа цайрдсан, өндөр чанарын нүүрстөрөгчийн гангаар хийсэн хоолой, холбох хэрэгслийг багтаасан орчин үеийн иж бүрэн систем юм.



Хаалттай төрлийн дотоод системд ашиглах зориулалттай, энэ нь: төвлөрсөн төвийн халаалт, усны хөргөлт, технологийн дулаан, нарны систем, жишээлбэл, шингэн түлшний систем дээр тулгуурласан үйлдвэрийн тоног төхөөрмжин дээр тус тус хэрэглэх зориулалттай.

KAN-therm Steel – ийг олон давхар орон сууцны барилга, нийтийн барилга байгууламж барихад шинэ дотоод халаалтын системийг суурилуулахад ашигладаг. Материалын онцлог, өргөн цар хүрээ нь хаалттай төрлийн системийг (хөргөлтийн шингэн рүү агаар нэвтрэхгүйгээр) бий болгох боломжийг олгодог.

KAN-therm Steel систем нь найдвартай, батлагдсан "Пресс" холболтын технологийн ачаар энгийн, хурдан, аюулгүй суурилуулалтаар тодорхойлогддог (ил гал ашиглахгүй технологи) бөгөөд ялангуяа орон сууцны байшингийн зэвэрсэн халаалтын төхөөрөмжөө солиход үүнийг ашиглахыг зөвлөж байна.



01

Хурдан болон хөнгөн угсралт

02

Аюулгүй болон найдвартай чанар

03

Үзэмжтэй, зэврэлтэнд тэсвэртэй

04

Өндөр даралт болон өндөр хэмд тэсвэртэй

05

Маш өндөр механик бат бөх чанар



SYSTEM KAN-therm

Inox

Ø12-168,3 мм

Энэ нь өндөр чанарын зэвэрдэггүй ган хоолой, холбох хэрэгслийг багтаасан өндөр бат бэх суурилуулалтын систем юм.



KAN-therm Inox нь (халаалт, усан хангамж, нарны систем), түүнчлэн төрөл бүрийн шингэн ба хий (хөргөсөн ус, ионгүйжүүлсэн ус, шахсан агаар, тос, тосолгооны материал болон түлш, химийн бодис) гэх мэт стандарт инженерийн системд хэрэглэхээр зориулагдсан юм.

KAN-therm inox систем нь дээд зэрэглэлийн барилгын материалыг ашигладаг тул үүний үр дүнд олон тооны орон сууц, олон нийтийн барилга байгууламжид амжилттай нэвтрүүлэн хэрэглэж, үйлдвэрлэлийн янз бүрийн технологийн суурилуулалтыг бий болгосоор байна.

01

Он удаан жилийн хэрэглээ даах материал

02

Дээд зэрэглэлийн чанар болон өнгө үзэмж

03

Зэврэлтэнд маш өндөр тэсвэртэй

04

Зэврэлтэнд маш өндөр тэсвэртэй

05

GIGA гидравлик



SYSTEM KAN-therm

Groove

ØDN25-DN300 мм

KAN-therm Groove бол DN25-DN300 диаметртэй хоолойг механикаар холбоход хэрэглэгддэг тусгай ховилын заавар бүхий холбох хэрэгсэл, холбогчоос бүрдэх угсралтын систем юм (бид хувь хүний захиалгаар илүү том диаметртэй элементүүдийг нийлүүлэх боломжтой). Систем нь найдвартай холболт, түүнчлэн хурдан, энгийн, аюулгүй суурилуулалтаар тодорхойлогддог.

Үйлдвэрлэлийн процесст орчин үеийн технологийг ашигладаг тул KAN-ы бүтээгдэхүүнүүд хамгийн хатуу шаардлагыг хангаж, үндэсний болон олон улсын чанарын гэрчилгээтэй байдаг.

Ашигласан материалын хамгийн өндөр чанар, өргөн хүрээний диаметр, түүнчлэн 69 бар хүртэлх өндөр даралтын эсэргүүцлийг харгалзан систем нь шахсан агаарын суурилуулалтанд, түүнчлэн үйлдвэрлэлийн салбарт, усан онгоцны үйлдвэрт мөн уул уурхайн салбарт тус тус ашиглагддаг.

Системийг ашиглах боломж нь орон нутгийн шаардлага, дүрэм журмаас хамаардаг тул дэлхийн өөр өөр зах зээл, бүс нутагт өөр өөр байж болно. Суулгахын өмнө системийн тохиромжтой байдлыг одоогийн орон нутгийн дүрэм журам, шаардлага, түүнчлэн одоо байгаа гэрчилгээний дагуу шалгаж байх ёстой.



- 01** Диаметрийн өргөн цар хүрээ
- 02** Шалгагдсан материал
- 03** Онцгой бат бөх чанар
- 04** Энгийн угсралт
- 05** Бүрэн аюулгүй байдал

* Тодорхой элементүүд гээр тэрчилгээ (сертификайт) хязгаарлагдмал байж болох иуул сонгосон элементүүдаг зориулсан тэрчилгээ байгаа эсэхийг шалгана уу.



SYSTEM KAN-therm

Copper

Ø12-108 мм

KAN-therm Cooper - энэ бол CU-DHP зэс, 12-108 мм диаметртэй 2v109 хүрлээр хийсэн өндөр чанартай холбох хэрэгслийг багтаасан орчин үеийн суурилуулалтын систем юм. "press" холболтын технологийг ашиглах нь энгийн суурилуулалт, түүнчлэн тоног төхөөрөмжийг асуудалгүй ажиллуулах баталгаа болдог.

KAN-therm Cooper нь олон давхар орон сууцны барилгад дулаан, хүйтэн ус хангамжийн шинэ, дотоод халаалтын систем (хангамжийн өргөгч ба хэвтээ түгээлтийн шугам хоолой) суурилуулахад зориулалттай юм.

Холбох хэрэгсэл (зэс) үйлдвэрлэхэд ашигласан материалын өндөр чанарыг харгалзан KAN-therm Cooper системийг өндөр стандарт бүхий төслүүдэд, тухайлбал цэвэр ариун байдалд өндөр шаардлага тавьдаг хөрөнгө оруулалтанд, жишээ нь эмнэлэг, лаборатори, эмчилгээний өрөөний халаалт, усан хангамжийн системд ашиглахыг зөвлөж байна.



01

Аюулгүй байдал

02

Энгийн болон найдвартай байдал

03

Найдвартай, 3 цэгийн хавчилт

04

Хэмнэлттэй

05

Гоо зүй, харагдах байдал, өнгө үзэмж сайтай, зэврэлтэнд тэсвэртэй



SYSTEM KAN-therm

Sprinkler

Ø22-108 мм

KAN-therm Sprinkler – энэ нь 22-108 мм (DN20-DN100) диаметртэй нүүрстөрөгчийн ган (Steel Sprinkler) эсвэл зэвэрдэггүй ган (Inox Sprinkler) хоолой, холбогчийг багтаасан гал унтраах суурилуулалтын угсралтанд зориулсан бүрэн суурилуулалтын систем юм.



KAN-therm Sprinkler нь ус шүршигч болон галын цорго бүхий дотоод гал унтраах байгууламжийг бий болгоход зориулагдсан. Хоёр төрлийн материалыг VdS-ийн шаардлагын дагуу шалгаж, баталгаажуулсан бөгөөд галын аюулын бага ба дунд зэрэгт дохиоллын хавхлагатай суурин шүршигч системд ашиглах боломжтой (LH, OH1, OH2, OH3 ба OH4 - үзэсгэлэнгийн танхим, кино театр, театр, концертын танхимд хамаарна) мөн галын цорго бүхий дотор суурилуулалтанд ашиглахыг зөвшөөрсөн.

KAN-therm Steel болон Inox Sprinkler системийг суурин гал унтраах байгууламжид ашиглах боломжийг CNBOP-ийн Үндэсний Техникийн Үнэлгээгээр (Галаас хамгаалах эрдэм шинжилгээний судалгааны төв) зөвшөөрсөн байдаг. KAN-therm Steel Sprinkler систем нь байнга усаар дүүргэсэн шүршигч суурилуулалт, түүнчлэн галын цорго бүхий суурилуулалт (гидрант), нэг талдаа холбогдсон эсвэл усан хангамжийн системээс бүрэн тусгаарлагдсан суурилуулалтанд тус тус зориулагдсан болно. KAN-therm Inox шүршигч системийг "нойтон" (усаар дүүргэсэн) эсвэл "хуурай" (хуурай хоолой) суурин усан гал унтраах шүршигч суурилуулалт, мөн дотоод байнгын усаар дүүргэсэн гал унтраах байгууламжид (цорго) ашиглаж болно.



* Зөвхөн KAN-therm Inox Sprinkler-г хамаарна.

01

Аюулгүй хурдан угсралт

02

Үзэмжтэй угсралт

03

Зэврэлтэнд маш тэсвэртэй

04

Галын аюулгүй байдал

05

Баталгаажсан чанар



SYSTEM KAN-therm

Хавтант халаалт болон хөргөлт

Ø8-25 мм

Барилгын хашааны гадаргууг өрөөний дулаан, хүйтний эх үүсвэр болгон ашигладаг бага температурт усан суурьтай хавтант-цацрагийн халаалт, хөргөлтийн систем (шалны, хананы, таазны).

KAN-therm нь эрчим хүчний хэмнэлттэй, найдвартай усны хавтант, халаах ба / эсвэл хөргөх системийг бий болгох орчин үеийн техникийн цогц шийдлүүдийг санал болгодог, үүнд: хоолой, дулаан тусгаарлагч, холбох элементүүд, коллекторын групп, угсралтын шкафнууд, хяналтын автоматжуулалт зэрэг.

Тасалгааны температурыг маш сайн хуваарилсны ачаар агаарын температурыг доошлуулж болох ба ингэхдээ дулааны тав тухыг хадгалан харин өгөгдөж буй дулааны эрчим хүчний хэмжээг бууруулна.



01

Байрны ашиглалтын гоо зүй, тав тухтай байдал

02

Хөнгөн угсралт

03

Элементуудын өндөр чанар

04

Дулааны энергийн хэмнэлт

05

Он удаан жилийн аюулгүй ажиллагаа

SYSTEM KAN-therm

Удирдлагын автоматик

KAN-therm SMART & Basic + нь дулаан эсвэл хүйтэн эх үүсвэрийг оновчтой ажиллуулах, мөн бүх халаалт, хөргөлтийн системийн өндөр эрчим хүчний хэмнэлтээр барилгын дулааны ая тухыг хадгалах боломжийг олгодог бие даасан нэгдсэн удирдлагын хоёр систем юм.

Халаалтын технологийн салбар дахь шийдлүүдийн олон талт байдал, юуны түрүүнд холимог халаалтын системийг маш тархмал ашиглах, жишээлбэл, шалны халаалтыг уламжлалт радиаторын халаалттай хослуулан халаасан шал нь олон давуу талтай хэдий ч зохих хяналтын элементуудыг ашиглахгүйгээр ихээхэн таагүй байдал үүсгэж болох юм. Ихэвчлэн энэ нь хэт халаалт, дутуу халаалт, эсвэл зарим нэгэн өрөө тасалгаануудад температурыг жигд бус хуваарилахтай холбоотой үүсдэг асуудал юм.

Хувь хүний халаалтын системийг хянадаг оновчтой тохируулсан автоматжуулалт байхгүй байгаа нь эрчим хүчний ихээхэн алдагдалд (байрны хэт халалт) хүргэж, улмаар халаалтын системийг ажиллуулах зардлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Өрөө тасалгааны температурын оновчтой хуваарилалтын ачаар агаарын температурыг бууруулах боломжтой бөгөөд энэ нь нийлүүлсэн дулааны энергийн хэмжээг бууруулж өгнө.



01

Утастай болон утасгүй удирдлага

02

Халаалт болон хөргөлтийн

03

Орчин үеийн дизайн

04

Хөдөлгөөнт хавсралтын удирдлага

05

Эрчим хүчний хэмнэлт



Шүүгээнүүд

Slim & Slim +

Slim and Slim + суурилуулсан шүүгээний онцлог шинж чанар нь KAN дизайнеруудын боловсруулсан хүрээгүй бүтээц юм.



Slim гэх нэршил нь нүүрэн хэсгийн тусгай нимгэн бүтээц өөрөөр хэлбэл (slim) хананы гадаргуу дээр төгс наалдаж тохирох эх биеийн урд хэсэгтэй холбоотой юм. Хөрөнгө оруулагчид тэдний орчин үеийн загвар, өндөр эрүүл ахуй шаардлагад нийцэх өндөр зэрэглэлийн чанар, гоо зүйн байдлыг үнэлэх нь гарцаагүй. Мөн суурилуулан угсрагчид нэмэлт хэрэгсэл шаарддаггүй хялбар, хурдан угсралт, түүнчлэн энгийн загварт нь сэтгэл хангалуун байх болно.

Шүүгээнүүд нь орчин үеийн дизайн, угсралтыг ханд суурилуулалтыг хөнгөлж өгөх олон шинэ шийдлүүдээрээ ялгардаг. Энэхүү инновац шийдлийг боловсруулахдаа KAN компани нь энэхүү бүтээгдэхүүний функцийг боловсхонгуй болгоход улам их анхаарал тавьсан юм.



- 01** | Гадаргууны хамгаалалт
- 02** | Хөнгөн угсралт
- 03** | Гүний тохиргоо
- 04** | Move & Lock
- 05** | Цэвэрхэн, үзэмжтэй гадаргуу
- 06** | Шалны өндрийн талаархи мэдээлэл

Коллекторын группууд InoxFlow

1.4301 зэвэрдэггүй гангаар хийсэн KAN-therm – ын коллекторын группуудын шинэ цуврал.



Үйлдвэрлэлийн шинэлэг технологи, түүнчлэн гуулин бүтэцтэй харьцуулахад илүү том дотоод хэмжээс бүхий, хананы зузаан илүү нимгэн зэвэрдэггүй ган дам нурууг ашигласнаар KAN-therm InoxFlow олон талт бүлгүүдийн гидравлик боломж нь механик бат бөх чанараа буулгахгүйгээр гуулин хувилбаруудтай харьцуулахад бараг хоёр дахин дээшлэсэн байна.

KAN-therm InoxFlow – ын бүх коллекторын группуудын дам нуруунд 10 жилийн баталгаат хугацаа, тохиргооны элементууд, автоматикийн элементууд болон эргэлтийн шахуурганд тус тус 2 жилийн баталгаат хугацаа олгогдоно.

Шинэ KAN-therm InoxFlow олон талт бүлгүүдийн өргөн сонголтууд нь одоо байгаа гуулин загвартай 100% адилхан бөгөөд алсдаа KAN-therm системийн санал болгож буй одоогийн сонголтуудыг орлуулах болно.



01

Чанартай сайн материал

02

Урсгалыг хөнгөн танин тогтоох

03

Дам нурууг эргүүлж тойруулах боломж

04

Өндөржүүлсэн үр ашиг

05

Энгийнээр танин мэдэж тогтоох

06

KAN-therm-ийн бусад шийдлүүдтэй нийцнэ



SYSTEM KAN-therm

Орон сууцны хуваарилан түгээгчдийн модулиуд

Орон сууцны хуваарилан түгээгч модуль гэдэг нь олон давхар байшингийн орон сууцыг хүйтэн, халуун ус, хөргөлтийн бодисоор хангах зориулалттай угсармал хуваарилагч зангилаа буюу нэгжүүдийг хэлнэ.

Халаалтын системийн дулааны эрчим хүчний хэрэглээ (дулааны тоолуур), усан хангамжийн системийн усны хэрэглээг (усны тоолуур) нэг иж бүрэн загвараар хэмжих хоёр нэгжийг зохион байгуулах боломжийг танд олгоно. Орон сууцны хуваарилан түгээгч модуль гэдэг нь суурилуулалтын зах зээл дээр хараахан үзэгдээгүй шинэлэг, авсаархан техникийн шийдэл юм. Энэхүү загвар нь хуулиар хамгаалагдсан бөгөөд патентлагдсан болно.

Орон сууцны хуваарилан түгээгч модулийг барилгын талбайд бэлэн угсармал бүтэц хэлбэрээр хүргэдэг бөгөөд энэ нь цаг хугацаа хэмнэж, суурилуулахтай холбоотой зардлыг бууруулж, улмаар барилгыг ашиглалтад оруулах ажлыг хурдасгадаг. Энэхүү шинэлэг бүтээгдэхүүн нь халаалт, усан хангамжийн системийн ус өргөгчтэй холбогдоход бэлэн байдаг тул битүүмжлэлийг шалгах буюу өөрөөр хэдбэл гоожсон эсэхийг яаралтай шалгах боломжийг олгодог. Хуваарилагчтай хүрээ дээр суурилсан авсаархан загвар нь ашигтай амьдрах орон зайг хэмнэх боломжийг олгодог тул нэгэн доор гоо зүйн болон функционал шийдэл болох юм.



PATENT PROTECTION



01

Авсаархан бүтээц

02

Тохиргооны олон талт байдал

03

Угсралтын цагийг хэмнэнэ

04

Амьдрах талбайг хэмнэнэ

05

Битүүмжлэлийг хойшлуулшгүйгээр түргэн шалгана



SYSTEM KAN-therm

Football

KAN-therm Football нь тусгайлан боловсруулсан, шилж сонгосон, харилцан уялдаатай иж бүрэн систем бөгөөд гадны гадаргууг халаахад зориулагдсан юм.

KAN-therm Football системийн элементууд нь тодорхой хөрөнгө оруулалтаар бэлтгэгддэг юм. Хөрөнгө оруулалтын талаархи цуглуулсан мэдээлэл, хөрөнгө оруулагчийн шаардлагын дагуу техникийн баримт бичгийг боловсруулж, үүний дагуу бие даасан бүтээгдэхүүнийг сонгох, бэлтгэх үйл явцыг эхлүүлдэг. KAN-therm Football систем нь томоохон хэмжээний хөрөнгө оруулалтад зориулагдсан юм.

Хөл бөмбөгийн талбайны ногоон хэсгийн халаалтыг зохион байгуулахад KAN-therm-ын системийг хэрэглэсний ачаар талбай мөстөж хөлдөх, цасаар хучигдах, эсвэл стадионы гадаргуу шавар шавхайгаар хучигдах зэрэг үзэгдлүүдтэй хийдэг тэмцэл бүгд улиран алга болжээ.

Хөл бөмбөгийн талбайн зүлгийн халаалтыг KAN-therm системаар гүйцэтгэснээр хөл бөмбөгийн талбайг бүтэн жилийн турш ашиглах боломж өгч мөн тоглогчдын гэмтэл бэртлийн эрсдэлийг хамгийн бага хэмжээнд буулгаж чаджээ.



01

Хөрөнгө оруулалтыг цогц үйлчлэх

02

Материалын дээд зэргийн чанар

03

Ажлын туршлага

04

Хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх явцад тусламж үзүүлэх

05

Ашиглалтын аюулгүй байдал



Багаж хэрэгслүүд ultraLINE

KAN-therm ultraLINE – системийн бүхий л элементууд тусгайлан зориулагдсан багаж хэрэгслийн тусламжтай холбогдох ёстой юм. Эдгээр багажууд нь тухайн системийн төрөлд багтдаг.

Хөнгөн, авсаархан загвар, суурилуулсан гар чийдэн нь барилгын талбай дээр ажиллахад тав тухтай, аюулгүй байдлыг ихээхэн нэмэгдүүлдэг. Зай цэнэглэх индикатор нь багаж хэрэгслийг тогтмол хянах, урьдчилан бэлтгэх боломжийг олгодог бөгөөд энэ нь суурилуулагчдад (угсралтыг ханд ажлын цагийг зохион байгуулах, хэмнэх боломжийг олгодог.



Багаж хэрэгслүүд PP

Хоолой, фитингуудаас (холбогчоос) гадна KAN-therm PP гэдэг нь холболтыг гүйцэтгэхэд зориулагдсан орчин үеийн гагнуурын багаж хэрэгслийн бүрэн цоморлиг юм.

Холболтыг зөв гүйцэтгэх нь суурилуулсан тоног төхөөрөмжийн аваар осолгүй мөн урт удаан хугацааны ажлын гүйцэтгэлд ихээхэн нөлөөг үзүүлдэг тул KAN-therm PP системийн угсралтын бүхий л багаж хэрэгсэл нь нарийн хяналт шалгалтаар ордог ба KAN-ы лабораторийн маш хатуу туршилтыг давдаг юм.



Багаж хэрэгслүүд Радиал буюу хавчигч-пресс

Алдартай болон нэр хүнд бүхий
багаж хэрэгслийн үйлдвэрлэгчдийн
хоолойнуудыг хавчихад зориулсан
радиал-прессудын өргөн хүрээ.

Жижигхэн, хөнгөхөн болон авсаарханаас эхлээд 100
тонн хүртэл хүчийг ялгаруулж чадах хүчирхэг,
бат бөх багаж хэрэгслүүд.



Багаж хэрэгслүүд ultraPRESS

16-40 мм-ийн диаметруудад зориулагдсан пресс буюу
базагч-бахиудтай KAN-therm – ын шинэ
персонал багаж хэрэгслүүд.

- U болон TH базагч-бахиудтай мэргэжлийн багаж хэрэгслийн гурван багц
- Тэд бүгд автомат урвуу базагч-бахиудаар тоноглогдсон!
- Багаж хэрэгслийн шинэ, бат бөх хайрцаг



SYSTEM KAN-therm

Steel, Inox

SYSTEM KAN-therm

Sprinkler

SYSTEM KAN-therm


Copper



Хувийн байшингуудад суурилуулахад зориулагдсан, 16-32
миллиметрийн, KAN-therm-ын MINI шинэ пресс-багаж (базагч-багаж)

- Жижигхэн, хөнгөхөн, эвтэйхэн, 2 аккумулятораар хангагдсан түргэн цэнэглэгч бүхий
- Аккумуляторууд нь ultraLINE – ны багажуудтай нийцэж таардаг
- Хайрцагны эх бие дээр тал бүрийн хэрэгцээ бүхий шугам бий
- 360 градус эргэдэг толгой нь фиттинг уруу багажийг яаж ч ойртох боломжийг өгдөг





KAN-therm-ын мультисистемийн шийдлийг Варшав хотын 8/10 өндөрлөг байрнуудад ашиглаж байна

Эдгээр системүүд дэлхийн олон орнууд болон нийт Польшийн нутаг дэвсгэр дээрхи мянга-мянган орон сууц, үйлдвэрийн болон спортын объектууд дээр ашиглагдаж байна. 30 гаруй жилийн туршид KAN-therm-ын шийдлүүд хамгийн нэр хүнд бүхий объектуудын N1 сонголт болсоор байна.





Өндөр чанарын хамгийн сайн нотолгоо бол барилгын салбарын янз бүрийн салбар дахь олон тооны төслүүд юм. Энэ нь шинэ хөрөнгө оруулалт болон шинэчлэгдсэн барилгуудын хувьд хамгийн тохиромжтой шийдэл юм.

Үүнийг KAN компанийн дизайнеруудын олон жилийн туршлага, мэргэжлийн өндөр ур чадвар, түүхий эд, эцсийн бүтээгдэхүүний чанарын хатуу хяналт, тогтвортой барилгын шаардлагад нийцсэн барилгын зах зээлийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй тодорхойлсон байдал нотолж байна.


Зураг төсөл, ТООЦООЛОЛД зориулсан KAN программ

KAN нь зөвхөн систем, бүтээгдэхүүн төдийгүй тооцоолол хийх, дүн шинжилгээ хийх цогц, орчин үеийн програм хангамж юм.

Та зураг төслийн хамгийн орчин үеийн аргыг ашиглаж болно – энэ нь PRO хувилбар дахь KAN SET программыг ашиглан BIM концепц дотор багтах төсөл юм.

BIM

BUILDING INFORMATION MODELING



QR-г сканнердах
суулгах код
програмууд



KAN SET 7.3

Энэ бол халуун, хүйтэн ус хангамжийн системийн тооцоог эргэлтийн хамт, халаалт, хөргөлтийн системийг нэг төсөлд нэгтгэсэн иж бүрэн зураг төслийн платформ юм. KAN SET бол дизайнеруудын ажлыг ихээхэн хөнгөвчлөх, хурдасгах өвөрмөц хэрэгсэл юм.



Халуун, хүйтэн ус хангамжийн системийг эргэлтийн хамт тооцоолох модуль.



Төвийн болон шалны халаалтын системийг тооцоолох модуль.



Хөргөлтийн системийн тооцооны модуль.

Гар утасны хавсралтууд

KAN гар утасны хавсралт бүхий програмууд нь ашиглахад хялбар бөгөөд гар доор байгаа хамгийн сүүлийн үеийн материал, багаж хэрэгслийг ашиглахад эвтэй, тустай бөгөөд түүнийг ашиглаж чадах баталгаа нь болно. KAN гар утасны шинэ програмуудыг ухаалаг утас эсвэл таблет дээрээ татаж авах боломжтой болсон юм.





KAN Multi App нь Суурилуулалтын ажлын явцад таны хувийн туслах болох орчин үеийн гар утасны программ юм.



Энэ бол KAN-therm Smart системийг удирдах ухаалаг хэрэгсэл бөгөөд дэлхийн хаанаас ч байшин доторхи температурыг хянах, зохицуулах боломжийг олгоно.



Таны өдөр тутмын ажилд тусалж, самбарын цацрагт системийг тохируулах үйл явцыг ихээхэн хурдасгаж өгнө.





KAN-therm ГЭСЭН ХУДАЛДААНЫ ТЭМДЭГТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД ТИВ ДЭЛХИЙН 68 УЛСАД ЭКСПОРТЛОГДДОГ ЮМ.

Албан ёсны дистрибьюторын сүлжээ нь Европ, Ази, Африк, Америкийн ихэнхи хэсгийг хамардаг.



ТӨВ БАЙР

KAN Group

Zdrojowa St. 51, 16-001 Kleosin, Poland.

tel. +48 85 74 99 200

e-mail: kan@kan-therm.com

kan-therm.com

Multisystem **KAN-therm**

Дотоод ус хангамж, халаалт, гал унтраах, технологийн тоног төхөөрөмжийн шугам хоолойн тоног төхөөрөмжийн салбарт орчин үеийн нэмэлт техникийн шийдлүүдийг багтаасан иж бүрэн суурилуулалтын олон систем буюу мультисистем.

	ultraLINE	
	ultraPRESS	
	PP	
	Steel	
	Inox	
	Groove	
	Copper, Copper Gas	
	Sprinkler	
	Хавтант халаалт болон хөргөлт, автоматик	
	Football Стадионд зориулагдсан тоног төхөөрөмж	
	Суурилуулалтын шүүгээнүүд болон коллекторын бүлгүүд	